



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙНТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2020

**ХУУЛЬ ЗҮЙН
СУДАЛГААНЫ ТӨВ**

**Улаанбаатар хот
2020**

Судалгааг удирдсан:

Ж.Амарсанаа

ХЗҮХ-ийн зөвлөх, академич

Д.Зүмбэрэллхам

ХЗҮХ-ийн төслийн зөвлөх, хууль зүйн доктор

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Алтансүх

ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр

Ж.Ариунцэцэг

ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг хянасан:

С.Энхцэцэг

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

ГАРЧИГ

УДИРТГАЛ	3
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	4
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	5
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	5
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	6
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	7
2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	7
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	8
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	8
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал..	13
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	15
3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	22
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	25
4.1. Үнэлэлт, дүгнэлт.....	25
4.2. Зөвлөмж.....	28
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	31
ХАВСРАЛТ	32
Нэг. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухам хуулийн төслийн үзэл баримтлал	32
Хоёр. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга.....	37
Гурав. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл	39

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.22 дахь хэсэгт “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ”, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх” гэж тусгасан. Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газраас баталсан аргачлалыг баримтлан “Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж, хуулийн төслийг боловсронгуй болгох санал боловсруулахад оршино.

Түүнчлэн энэхүү судалгаагаар “Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгохыг зорьсон. Мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилоо.

“Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуураас 4 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараахь үндэслэлийг харгалзан үзсэн. Үүнд:

1. Хуулийн төсөл ньхүний эрхийн хамгаалагчийн эрхийг баталгаажуулах, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах зорилгодоо хүрсэн эсэх;
2. Хуулийн төслөөр хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгох хүрээнд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо гэсэн шинэ бүтэц бий болгож, түүнд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахтай холбогдох үүрэг хариуцуулсан зохицуулалт практикт хэрэгжих эсэх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик уялдаатай боловсруулагдсан эсэх;
4. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгана.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгов. Эдгээр зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Тус хуулийн төслийг хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд боловсруулсан¹ бөгөөд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилго нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад оршино гэж заасан. Мөн Загвар хуулийн үзэл баримтлал, танилцуулгад хүний эрхийн хамгаалагчийг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөх, хамгаалах нь тэдний үйл ажиллагааг дэмжих, эрсдэлгүй орчинд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилгыг хангах талаар тусгасан байдаг.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бий болгох гэдэг нь хүний эрххамгаалах эрхийг баталгаажуулах, төрийн байгууллагын зүгээс хүлээх үүргийг тодорхой болгох, энэ зорилгоор тусгайлсан бүтэц байгуулах цогц ажиллагаа болох талаар тунхаглал, загвар хууль болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжүүдэд тусгасан байдаг. Хүний эрх хамгаалах эрхийг баталгаажуулах хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай холбоотой үндсэн эрхүүдийг баталгаажуулах, хуулиар хамгаалах, зөрчигдсэн тохиолдолд түүнийг шийдвэрлэх, сэргээн эдлүүлэх зохицуулалтыг бий болгодог бол хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах бүтэц бий болгосноор эрсдэлд өртсөн болон өртөж болзошгүй хүний эрхийн хамгаалагчийг ямар журмаар, хэн, хэрхэн хамгаалах талаарх асуудлыг шийдвэрлэдэг байна.

Төслийн үндсэн зорилго нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах эрх зүйн орчин бий болгоход орших тул энэхүү үндсэн зорилгыг ямар хэмжээнд хангаж байгааг дээр дурдсан арга хэрэгслүүдийн хүрээнд үр нөлөөг нь тооцлоо. Эдгээрээс хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгохтой холбогдох зүйл заалтыг дараагийн хэсэгт буюу практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэв.Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Хүний эрх хамгаалах эрхийг баталгаажуулах	Хуулийн төслийн 6 дугаар зүйл, 8.1.1, 12.1.4 дэх заалт
2	Хүний эрхийн хамгаалагчид	Хуулийн төслийн 9.2.2, 12.1.7 дахь заалт

¹Хуулийн төслийн үзэл баримтлал.

	халдсан үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрх хамгаалах үйл ажиллагааны онцлогийг харгалзах зохицуулалт бий болгох	
3	Гадаад улсад Монгол Улсын иргэн хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах	Хуулийн төслийн 9.3 дахь хэсэг

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгох зорилгоор Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо /цаашид Хороо гэх/ гэсэн шинэ бүтэц бий болгож, түүндхүний эрхийн хамгаалагчийг хамгаалахтай холбогдох тодорхой эрх мэдэл олгосонтой холбогдуулан энэ талаарх зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1	Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгохтой холбогдох зохицуулалт	<p>6 дугаар зүйл. Хүний эрхийн хамгаалагчийн эрх</p> <p>6.1. Хүний эрхийн хамгаалагч дараахь эрхтэй байна.</p> <p>6.1.15. өөрт болон энэ хуульд заасан бусад хүн эрсдэлд өртсөн, өртөх нөхцөл бодитой бүрэлдсэн тохиолдолд гэрч, хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдтэй дүйцэхүйц хамгаалалт хүсэх.</p> <p>9 дүгээр зүйл. Төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг</p> <p>9.2. Хүний эрхийн хамгаалагчийн талаар төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>9.2.1. цагдаагийн байгууллага нь хүний эрхийн хамгаалагчид халдсан халдлагыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу таслан зогсоох, хамгаалалтад авах.</p> <p>12 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх</p> <p>12.1. Хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.5. хүний эрхийн хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлын дагуу түүнийг таслан зогсооход чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авах</p> <p>12.1.6. эрсдэлийн үнэлгээ хийх, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад шаардагдах хэрэгцээг тодорхойлох.</p>

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 4 бүлэг, 14 зүйлтэй./

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 4 бүлэг, 14 зүйлтэй./

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 6 дугаар зүйл, 8.1.1, 12.1.4 Хуулийн төслийн 9.2.2, 12.1.7 Хуулийн төслийн 9.3	Зорилгод дүн шинжилгээ хийсэн.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 6.1.15, 9.2.1, 12.1.5, 12.1.6	Тухайн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийсэн.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгасан.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгасан.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ:

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хүний эрххамгаалах эрхийг баталгаажуулах зорилтын хүрээнд 6 дугаар зүйл, 8.1.1, 12.1.4 дэх заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд хүний эрхийн хамгаалагчийн эрхүүдийг тусгасан. Энэ хэсэгт эдгээр заалт зорилгодоо хүрэхүйц байгаа эсэхийг шалгах буюу хүний эрх хамгаалах эрхийг баталгаажуулж, тэдгээр эрх хэрэгжих эрх зүйн баталгаа

бий болгосон эсэхийг авч үзэх юм. Мөн эрх зөрчигдсөн тохиолдолд түүнийг шийдвэрлэх, сэргээн эдлүүлэх зохицуулалтыг бий болгосон эсэхийг шалгана.

Үүнийг дүгнэн авч үзэхээс өмнө хүний эрх хамгаалах эрхийг баталгаажуулах талаарх олон улсын туршлага, ерөнхий зарчмыг авч үзэх нь зүйтэй юм. Хүний эрх хамгаалах эрхийг баталгаажуулах, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах эрх зүйн уламжлал Европын орнуудад тогтсон, эдгээрийг хүний эрхтэй холбогдох хууль тогтоомжуудад нэгэнт тусгасан, түүнийг хэрэгжүүлэх практик тогтсон гэж үздэг байна². Иймд эдгээр орнуудын зүгээс гуравдагч ертөнцийн орнуудад хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хангах тухай асуудлыг гадаад харилцааны бодлого, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд анхааруулсаар ирсэн³. Гуравдагч ертөнцийн орнуудын хувьд хүний эрхийн хамгаалагчид халдах эрсдэл өндөр, зарим тохиолдолд төр өөрөө халдагч, эрхийг нь хязгаарлагч байх тохиолдол байдаг нь хүний эрхийн хамгаалагчийн талаарх ойлголтыг тодорхой болгох, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тусгай механизм бий болгох асуудал олон улсын түвшинд тавигдах нэг үндсэн шалтгаан болдог. Энэ ч үүднээс Ази, Африк, Латин Америкийн зарим орон энэ чиглэлийн хууль тогтоомж баталж, олон улсын түвшинд Загвар хууль гарсан.

1998 онд батлагдсан Хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглал нь шинэ эрх бий болгоогүй, харин хүний эрх хамгаалах үйл ажиллагаанд холбогдох олон улсын хүний эрхийн зарчим, хэм хэмжээг дахин бататгасан байдаг. Мөн Загвар хуулийн танилцуулгад эдгээр эрхийг дахин баталгаажуулж тусгах нь практикт бодитоор хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх, олон нийт, төрийн байгууллагын зүгээс хүлээн зөвшөөрөх баталгааг бий болгох ач холбогдолтой гэж тусгасан.

Түүнчлэн хууль санаачлагч болон иргэний нийгмийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр нийгэмд хүний эрхийн хамгаалагчийн тухай ойлголтыг өргөжүүлэх, хүний эрхийн хамгаалагчдад үйл ажиллагаагаа явуулах итгэл, урам зориг төрүүлэх нь тус хуулийн төслийн үндсэн зорилгын нэг болох талаар тодотгон дурдаж байсан.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд нийт 18 эрхийг жагсаан заасан бөгөөд 6.1.1-6.1.14 дэх заалтад хүний эрх хамгаалах эрх, хүний эрх хамгаалах үйл ажиллагааг саадгүй явуулах эрхийг баталгаажуулсан, 6.1.17 дахь заалтад зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, гомдол гаргах, хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулсан, 6.1.18 дахь заалтад цахим мэдээлэлд хууль бусаар халдахаас хамгаалуулах эрхийг баталгаажуулсан байгаа бол 6.1.15 дахь заалтад хамгаалуулах эрхийг тусгасан байна.

Өмнө дурдсанчлан хуулийн ерөнхий зарчим нь хүний эрх хамгаалах эрхийг баталгаажуулж, хүний эрхийн хамгаалагчийн статусыг хүлээн зөвшөөрч, хамгаалах механизмыг бий болгосноор хүний эрх хамгаалахад таатай орчин, эрх зүйн боломжийг бий болгоход чиглэгджээ.

Тунхаглал батлагдсанаас хойш тунхаглалын зарчмыг хэрэгжүүлэх, практикт хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд бий болж эхэлсэн байна. Тунхаглал, Загвар хууль, олон улсын байгууллагаас гаргасан

²Phil Lynch and others, 'From Restriction to Protection', 2014.

³2014 онд Universal Periodic Review-ийн 18 дугаар хуралдааны үр дүнд Австрали, Бельги, Бразил, Канад, Колумб, Чех, Дани, Унгар, Ирланд, Недерланд, Норвеги, Польш, Румын, Словек, Испани, Швейцарь, Их Британи, АНУ гэсэн орнууд бусад орнуудад хандан Тунхаглалын хүрээнд тусгайлсан хууль болон бодлогын баримт бичиг батлах, одоо байгаа эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, бэхжүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг гаргасан.

зөвлөмжүүд, энэ талаарх судалгаа зэргээс үзэхэд хүний эрхийн хамгаалагчийн эрхийн талаарх дараахь зарчим үйлчилж байна гэж үзэж болох юм. Үүнд, хүний эрхийн хамгаалагчийн гэсэн тусгайлсан эрх нь үйл ажиллагааныхаа хүрээнд эрсдэлд өртсөн, өртөж болзошгүй хамгаалагчийг хамгаалах асуудлын хүрээнд үүсэх, харин үйл ажиллагаа явуулахтай холбоотой үндсэн эрхүүд хүн бүрт хадгалагдах зарчим үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, хүний эрх хамгаалах эрх хүн бүрт хадгалагдах⁴ бөгөөд хэн ч хүний эрх хамгаалагч байх боломжтой. Харин хүний эрхийн хамгаалагч гэсэн ойлголтын хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагаанд саад учирсан, хүний эрх хамгаалах үйлдлийнхээ улмаас эрсдэлд өртсөн тохиолдолд хүний эрх хамгаалагч гэж хэн бэ гэдгийг тодорхойлох шаардлага бий болно. Иймд хүний эрхийн хамгаалагчийн тусгайлсан эрх гэдэг нь зөвхөн хамгаалуулах эрх л байх нь зүйтэй. Энэ зарчим нь мөн хэт дархлаажсан бүлэг бий болохоос сэргийлэх зорилгыг хангах ач холбогдолтой⁵.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай холбогдох үндсэн эрхүүдийг баталгаажуулан зааж өгсөн нь төсөл боловсруулагч, иргэний нийгэмтэй хийсэн уулзалтын үеэр дахин давтагдан гарч байсан таниулах, олон нийтэд итгэл үнэмшил төрүүлэх зорилгод нийцэж байна гэж үзэж байна. Гэвч эдгээр эрхийг хүний эрхийн хамгаалагчийн эрх гэж заасан нь учир дутагдалтай бөгөөд “хүн бүр хүний эрх хамгаалах эдгээр эрхийг эдэлнэ” гэж заах нь зүйтэй юм.

Хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулах эрхийг дэлгэрэнгүй зааж өгөх нь энэ төрлийн хууль ёсны үйл ажиллагаа явуулсныхаа улмаас гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос сэргийлэх ач холбогдолтой. Хүний эрхийн хамгаалагчийн үйлдлийг гэмт хэрэгт тооцох, гэмт хэргийн шинж үүсгэж авч үзэх асуудал нь олон улсын хэмжээнд анхаарал татсан, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахтай холбогдох үндсэн асуудлын нэг юм.

Харин хүний эрх хамгаалах эрхийг хамгаалах тухайд хуулийн төслийн 12.1.4 дэх заалтаар Хороо нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч, Хүний эрхийн Үндэсний Комисст шилжүүлэн шийдвэрлүүлэх эрхийг хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгосон. Мөн хуулийн төслийн 8.1.1 дэх хэсэгт төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээд нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, хүний эрхийн хамгаалагч хүчирхийллийн бус тайван замаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах нийтлэг үүрэг хүлээх тухай тусгасан. Иймд хамгаалагчийн эрх зөрчигдсэн тохиолдолд энэ талаарх мэдээлэл, гомдлыг Хороо хүлээн авч, Комисст шилжүүлэх талаар тусгасан тул 6 дугаар зүйл нь зорилгод хүрэхүйц байна. Гэхдээ эдгээр эрхийгтодорхойлохдоо хэт өргөн хүрээтэй, ойлгомжгүй байдлаар заасан асуудал

⁴Тунхаглалын 1 дүгээр зүйлд хүн бүр хувиараа болон бусадтай хамтран үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хэрэгжүүлэх, хамгаалах эрхтэй тухай заасан байдаг бөгөөд Загвар хуульд мөн энэ зарчмыг тусгасан.

⁵Нийтлэг хүний эрхүүдийг хууль тогтоомжоор баталгаажуулсан, хүний эрхийн нөхцөл харьцангуй сайн орнуудын тухайд хүний эрхийн хамгаалагчийг тусгайлан авч үзэж, эрх зүйн байдлыг нь тодорхойлох шаардлагагүй гэж үзсэн байдаг. Тухайлбал, Их Британи улс хүний эрхийн хамгаалагч нь дотоодын хууль тогтоомжид тусгай категори болж тусгайлан заагддаггүй боловч хүний эрх хамгаалах үйл ажиллагааг хэн ч явуулах эрхтэй, түүнийг бусад хүний эрхтэй холбоотой асуудлын адилаар хуулийн байгууллага эрхийг нь хамгаална гэж мэдэгдсэн байдаг. Гэвч үүнийг олон улсын зөвлөмжид тайлбарлахдаа аливаа нэг бүлгийн эрхийг хүлээн зөвшөөрөх асуудал тухайн эрх практикт хэрэгжих, олон нийтэд танигдах асуудалтай шууд холбогддог туршлагатай зөрчилдөж байна гэж үзсэн байна.

байгаа бөгөөд энэ талаар судалгааны дараагийн хэсэг буюу ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд шалгасан хэсгээс үзнэ үү.

Гадаад улсад Монгол Улсын иргэн хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах зорилгын хүрээнд 9.3 дахь хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн 3.2 дахь хэсэгт “гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах асуудлыг энэ хуульд заасан журмаар зохицуулна” гэж тусгасан. Мөн хуулийн төсөлд хүний эрхийн хамгаалагч гэж “... хүний эрхэм чанарыг үндэсний болон олон улсын түвшинд хамгаалж байгаа хүнийг” ойлгоно гэж тодорхойлсон.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан гадаад улсад Монгол Улсын иргэн хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах журмыг авч үзье. Хуулийн төслийн 9.3 дахь хэсэгт гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг дараахь байдлаар хамгаална гэж заасан. Үүнд:

- Хүний эрхийн хамгаалагчийг төлөөлөх хууль ёсны төлөөлөгчийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр томилох;
- Хүний эрхийн хамгаалагчийг тухайн улс дахь дипломат төлөөлөгчийн газар хүлээн авах, хүний эрхийн хамгаалагчийн гэр, ажлын газарт эсхүл эрх чөлөөг нь хязгаарласан газарт нэвтрэх;
- Хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлын талаар хяналт шинжилгээ хийх, мэдээлэх;
- Хүний эрхийн хамгаалагчийн холбогдсон хэрэг маргааныг мөрдөн шалгах, шүүх ажиллагаанд оролцох, ажиглах;
- Өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрчийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, дэмжлэг үзүүлэх;
- Эмнэлгийн шаардлагатай туслалцаа үзүүлэх;
- Шаардлагатай зорчих баримт бичгийг яаралтай олгох;
- Хүний эрхийн хамгаалагчийн гэр бүлийн гишүүдтэй холбоо тогтоох, мэдээллээр хангах;
- Хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн боломжит арга хэмжээ авах;
- Нэн тэргүүнд шаардлагатай санхүүгийн туслалцаа үзүүлэх.

Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект тодорхойгүй тул үр нөлөөтэй хэрэгжих боломжгүй байна. Хүчин төгөлдөр үйлчилж буй үндэсний хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн дагуу гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах асуудал нь дипломат албаны гадаад улсад өөрийн орны иргэнийг хамгаалах үндсэн үүрэгт шууд хамаарах билээ. Харин энэхүү хуулийн төслийн 10.1 дэх хэсэгт “Хороо нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэгтэй байгууллага мөн” гэж заасан.

Элчин сайдын яам, консулын өөрийн орны иргэнийг албан ёсоор төлөөлөх, эрхийг нь хамгаалах бүрэн эрх олон улсын нийтлэг хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн. Түүнчлэн хуулийн төслийн 9.3 дахь хэсэгт **хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлын талаар хяналт шинжилгээ хийх, мэдээлэх** зэрэг хараат бусаар хэрэгжүүлж болох чиг үүргээс гадна **шаардлагатай зорчих баримт бичгийг яаралтай олгох** зэрэг зөвхөн элчин сайдын яам, консулын газрын эрх хэмжээнд хамаарах үүргийг мөн тусгасан байна. Үүнээс үзэхэд дээрх зохицуулалтыг

хэрэгжүүлэх субъектэд элчин сайдын яам, консул зайлшгүй хамаарах нь тодорхой байна. Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд Хороо тодорхой бүрэн эрх эдлэхгүй тохиолдолд хуулийн зохицуулалтын дээрх хэсгийг гадаадад Монгол Улсын иргэнийг хамгаалах чиг үүрэг бүхий дипломат албаны нийтлэг үүрэг гэсэн хэсэг болгон өөрчлөх нь зүйтэй юм.

Харин дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд Хороо тодорхой үүрэг гүйцэтгэх тохиолдолд Хорооны эрх хэмжээ дипломат албаны эрх хэмжээтэй хэрхэн уялдах нь тодорхойгүй байна. Мөн энэ тохиолдолд гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах журмыг Хороо болон Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоох зохицуулалт бий болгох нь хэрэгжилтийн хувьд үр нөлөөтэй гэж үзэж байна.

Хүний эрхийн хамгаалагчид халдсан үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрх хамгаалах үйл ажиллагааны онцлогийг харгалзах зохицуулалт бий болгох зорилгын хүрээнд 9.2.2, 12.1.7 дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн 9.2.2 дахь хэсэгт “хүний эрхийн хамгаалагч амь насаа алдсан, сураггүй алга болсон, эрүү шүүлтэд өртсөн, хууль бусаар баривчлагдсан зэрэг тохиолдолд нэн даруй, нягт нямбай, үр дүнтэй, хараат бус, шударга мөрдөн шалгах ажиллагааг төрийн эрх бүхий мөрдөх байгууллага явуулах” үүрэгтэй гэж заасан.

Энэ заалт нь хүний эрх хамгаалах үйлдлийнхээ улмаас аливаа халдлагад өртөхөөс хамгаалуулах, өртсөн тохиолдолд хүний эрх хамгаалах үйлдэлтэй холбож шалгах зохицуулалтыг бий болгоогүй гэж үзэж байна. Хүний эрх хамгаалах үйлдэлтэй холбоотой зөрчлийн онцлог байдлыг анхаарах, энэ талаарх зөрчил, гэмт хэргийг шалгахдаа хүний эрх хамгаалах үйлдэлтэй холбож шалгах зохицуулалт бий болгох зорилгын хүрээнд үйлдэлтэй холбож шалгах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй гэсэн ойлголт олон улсын зөвлөмж, судалгаанд түгээмэл гардаг. Тухайлбал, заналхийлэлд өртсөн ямар ч хүн хуулийн дагуу хамгаалагдах ёстой. Гагцхүү хүний эрх хамгаалах үйлдлээс болж өртсөн бол энэ нөхцөлийг тусгайлан авч үзэх, хүний эрхийн хамгаалагч гэсэн онцлогийг нь харгалзах, ингэхдээ хамгаалах механизмыг татан оролцуулах үндсэн зарчим хэрэгждэг болохыг анхаарах нь зүйтэй юм.

Үйлдэлтэй нь холбож шалгах зохицуулалт бий болгох зорилго нь Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд хангагдаж, энэ хуулийн төслөөр түүнийг баталгаажуулах байдлаар зохицуулагдах боломжтой. Харин хуулийн төслийн дээрх заалтаар одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн санаатай үйлдсэн эсэхийг шалгах зохицуулалтыг ямар нэг байдлаар өөрчлөөгүй буюу шинэ нөхцөл байдал үүсгээгүй байна. Мөн “хүний эрхийн хамгаалагч амь насаа алдсан, тохиолдолд нэн даруй, нягт нямбай, үр дүнтэй, хараат бус, шударга мөрдөн шалгах ажиллагааг” явуулна гэж заасан нь зөвхөн хүний эрхийн хамгаалагчтай холбогдох тохиолдлыг нягт нямбай, үр дүнтэй шалгах хэрэгтэй мэт өрөөсгөл байдлаар ойлгогдохоор томъёологдсон байна.

Үүнээс гадна хуулийн төслийн 12.1.7 дахь хэсэгт Хороо нь “хүний эрхийн хамгаалагчид халдсан хэргийг мөрдөн шалгах явцад туслах, дэмжих, мэдээлэх, зөрчил гаргагчид хариуцлага хүлээлгэсэн эсэхийг мэдээлэх” эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан.

Дээр дурдсанчлан хүний эрхийн хамгаалагчид халдсан тохиолдолд Хорооноос эрсдэлийг үнэлэх тухай, мөн мөрдөн шалгахад туслах, дэмжлэг үзүүлэх тухай заасан

боловч хуулийн төслийн 9.2.2 дахь заалтад Хороо ямар ч нөлөөгүй, одоо байгаа зохицуулалтыг ямар нэг байдлаар дээрдүүлээгүй гэж үзэж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцах эрх, мөн эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааны талаарх гомдлыг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх эрх хэрэгжүүлдэг. Дээрх зохицуулалт нь одоо үйлчилж байгаа энэхүү зохицуулалтыг өөрчлөх, нөхцөл байдлыг сайжруулах нөлөөгүй байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Энэхүү хуулийн төслөөр Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо гэсэн шинэ бүтэц бий болгож, түүнд шинэлэг, практикт өмнө нь хэрэгжиж байгаагүй зарим үүргийг хариуцуулахаар байгаа тул практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр шалгах нь зүйтэй гэж үзлээ. Ингэхдээ хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгох зохицуулалттай холбогдох заалтууд практикт хэрэгжих боломжтой эсэхийг шалгах юм.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгох зохицуулалт практикт хэрэгжих боломжийг шалгах хүрээнд хуулийн төслийн **6.1.15, 9.2.1, 12.1.5, 12.1.6** дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Энэ хэсэгт хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах механизм бий болгож чадсан эсэхийг буюу түүнтэй холбогдох заалтуудын зорилгод хүрэх байдлыг шалган авч үзэв.

Хуулийн төслийн 6.1.15-д хүний эрхийн хамгаалагч нь “өөрт болон энэ хуульд заасан бусад хүн эрсдэлд өртсөн, өртөх нөхцөл бодитой бүрэлдсэн тохиолдолд гэрч, хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдтэй дүйцэхүйц хамгаалалт хүсэх” эрхтэй гэж заасан бол 9.2.1-д цагдаагийн байгууллага нь “хүний эрхийн хамгаалагчид халдсан халдлагыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу таслан зогсоох, хамгаалалтад авах нийтлэг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан. Харин хуулийн төслийн 12.1.5-д Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо нь “хүний эрхийн хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлын дагуу түүнийг таслан зогсооход чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авах”, 12.1.6-д Хороо “эрсдэлийн үнэлгээ хийх, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад шаардагдах хэрэгцээг тодорхойлох” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.

Олон улсын чиг хандлагыг авч үзэхэд ерөнхийдөө хоёр төрлийн хууль тогтоомж байна гэж үзсэн байна. Үүнд:

- Тунхаглалын зарчмыг нутагшуулах зорилго бүхий хүний эрхийн хамгаалагчийг тодорхойлж, мөн хамгаалах талаарх төрийн үүргийг тодотгосон хууль тогтоомж;
- Хамгаалалтын тусгай механизм бий болгож, түүний үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагааг заасан хууль тогтоомж.

Колумб, Мексик, Бразил, Непаль зэрэг орнууд хоёр дахь төрөл буюу тусгай механизмыг хуулиар бий болгосон. Гэвч эдгээр нь хараат бус, тусгай хамгаалалтын байгууллагын бүтэц бий болгож байгааг анхаарах нь зүйтэй юм.

Хамгаалах тогтолцоо нь зөвхөн биед нь халдсан, халдлагад өртөх эрсдэлд байгаа хамгаалагчийг хамгаалах төдий бус хүний эрх хамгаалах эрхийг мөн хамгаалах ёстой. Энэ хуулийн төслөөр хүний эрх хамгаалах эрхийг хамгаалах чиг үүргийн хувьд

одоо байгаа тогтолцоог хэвээр хадгалсан буюу Комиссын чиг үүргийн хэмжээнд үлдээсэн бол хамгаалагчийг хамгаалах тухайдасуудлыг дагнан хариуцах Хороог бий болгосон. Мөн хүний эрхийн хамгаалагч эрсдэлд өртсөн, эсвэл өртөх нөхцөл үүссэн тохиолдолд Цагдаагийн байгууллага арга хэмжээ авах нийтлэг үүргийг давтан тусгасан.

Үүнээс үзэхэд хуулийн төслөөр бий болгосон шинэ зохицуулалт нь Хорооны хүний эрхийн хамгаалагчид **халдсан тухай мэдээлэл, гомдлын дагуу түүнийг таслан зогсооход чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авах, эрсдэлийн үнэлгээ хийх, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад шаардагдах хэрэгцээг тодорхойлох** бүрэн эрх юм. Өөрөөр хэлбэл хамгаалалтын механизмын хувьд Цагдаагийн байгууллага хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, Хороо мөн тодорхой эрхийг хэрэгжүүлэх холимог тогтолцоог бий болгохоор байна.

Хэдийгээр Цагдаагийн байгууллагад үүрэг болгож, Хороонд шуурхай арга хэмжээ авах, эрсдэлийг үнэлэх, хамгаалалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох эрх хэмжээ олгосон боловч ямар процесс, журмаар хэрэгжих нь тодорхойгүй байна. Үүнд:

Нэгдүгээрт, Хорооноос **эрсдэлийн үнэлгээ хийх, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад шаардагдах хэрэгцээг тодорхойлох** эрхтэй гэж заасан. Үүнийг Цагдаагийн байгууллага ямар хэмжээнд хүлээн зөвшөөрөх, хоорондын холбоо, хамтын ажиллагаа ямар байх нь тодорхойгүй, үүнийг хуулийн төсөлд заагаагүй байна. Тухайлбал, Цагдаагийн байгууллага хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд Хороонд хандвал Хороо эрсдэл байгаа эсэхийг үнэлэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалт байгаа боловч үүнээс цааш ямар процесс явагдах тухайд, эрсдэл байна гэж үнэлбэл түүнийг зайлшгүй гэрч, хохирогчийн хамгаалалтад авах эсэх нь тодорхойгүй байна. Мөн тухайлбал, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ **шаардлага, зөвлөмж** гаргадаг. Харин хуулийн төслийн 10.2 дахь хэсэгт “Хороо нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бие даасан, хараат бус байдлаар ажиллана” гэж заасан. ЭндХороо эрсдэлийн үнэлгээ хийх, хамгаалах шаардлагыг тодорхойлох эрх мэдлээ ямар хэлбэрээр хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Хоёрдугаарт, Хороо шаардлагатай тохиолдолд хүний эрхийн хамгаалагчид халдсан халдлагыг зогсооход чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авахаар заасан боловч түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, үүнд Цагдаагийн байгууллага ямар үүрэг гүйцэтгэх нь тодорхойгүй байна.

Хамгаалалтыг хэрэгжүүлэх субъектуудыг тодорхойлсон боловч эдгээр субъектуудын хоорондын уялдаа, хамтын ажиллагаа тодорхойгүй байгаа тул практикт бүрэн хэрэгжиж, зорилгод бүрэн хүрэх боломжгүй гэж үзэж байна. Иймд хамгаалалтын механизм бий болгохтой холбогдох эдгээр заалтыг өөрчлөх, Цагдаагийн байгууллага, Хороо хоорондын хамтын ажиллагаа, чиг үүргийн уялдааг тодорхой болгох шаардлагатай.

Мөн хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүний эрхийн хамгаалагчийг тодорхойлох, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулах эрх зөрчигдсөн эсэхийг нотлоход хүндрэл учирч болзошгүй.

Учир нь хүний эрхийн хамгаалагчийг тодорхойлох тухайд хуулийн төслийн 3.3 дахь хэсэгт “тусгайлсан хуулиар эрх зүйн байдал нь тодорхойлогдсон хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлыг тухайн хуулиар зохицуулна” гэж хязгаар бий болгосон боловч 4.1.1 дэх заалтад хүний эрхийн хамгаалагчийг тодорхойлохдоо “ганцаараа эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхиүлэн дэмжиж,

тайван, хүчирхийллийн бус арга замаар хүний эрхэм чанарыг үндэсний болон олон улсын түвшинд хүндэтгэн хамгаалалж байгаа хүн” гэж ерөнхий байдлаар тодорхойлсон.

Харин хүний эрх хамгаалах үйл ажиллагааны хувьд хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт тусгасан “хүчирхийллийн бус арга, тайван замаар хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн хамгаалагчийн алдар хүнд, нэр төрийг хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх, ёс зүй, ёс суртахуунтай байж хүний эрх, эрх чөлөө, нийгмийн үнэт зүйлсийг хүндэтгэх, хүний эрхийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх” гэсэн хүний эрхийн хамгаалагчийн үүрэг, мөн 5.1 дэх хэсэгт заасан “хүний эрхэм чанарыг хүндэтгэх, хуульд үндэслэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ёс зүйтэй байх, хариуцлага зайлшгүй байх” гэсэн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны тусгай зарчмуудаар хязгаарлагдаж байна.

Эдгээр зохицуулалт нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэхээс гадна ойлгомжтой байдлын хувьд учир дутагдалтай байгаа бөгөөд судалгааны дараагийн хэсгээс энэ талаар дэлгэрүүлэн үзнэ үү.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөлтэй холбоотойгоор хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулан ярилцлага хийсэн. Мөн хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсгийн гишүүдтэй 2 удаагийн фокус ярилцлага хийсний үндсэн дээр уг хуулийн төслийн тодорхойгүй байгаа зүйл, заалтад нэмэлт тайлбар авсан.

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	4.1.1.“хүний эрхийн хамгаалагч” гэж ганцаараа эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхиүлэн дэмжиж, тайван, хүчирхийллийн бус арга замаар хүний эрхэм чанарыг үндэсний болон олон улсын түвшинд хүндэтгэн хамгаалж байгаа хүнийг;	Энэ хэсэгт“хүний эрхийн хамгаалагч” гэж ямар субъектийг ойлгох нь тодорхойгүй байна.	“Хүний эрхийн хамгаалагч”-ийг хэт өргөн хүрээгээр тодорхойлсон байгаатай холбогдуулан уг заалтыг ойлгомжтой байдлаар дахин томъёолох

2	6.1.2.хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх, хамгаалах зорилгоор албан болон албан бусаар төрийн бус байгууллага, эвсэл холбоо, бүлэг, түүнтэй адилтгах нэгдэл байгуулах, эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаанд нь оролцох;	Энэ хэсгийн “албан болон албан бусаар” гэсэн нь ойлгомжгүй байна.	“албан болон албан бусаар” гэснийг хуулийн төсөлд ойлгомжтой байдлаар тусгах
3	6.1.3.тайван жагсаал, цуглаан санаачлах, зохион байгуулах, энэхүү үйл ажиллагаагаа хууль бус аливаа нөлөөллөөс ангид байлгах;	Энэ хэсгийн агуулга нь хоёр өөр утгыг илэрхийлж байна. Тухайлбал, Хүний эрхийн хамгаалагч нь нэг талаас тайван жагсаал, цуглаан санаачлах, зохион байгуулах эрхтэй бол нөгөө талаар хууль бус нөлөөллөөс ангид байх эрхтэй гэж ойлгогдохоор байна. Иймээс эдгээр хоёр өөр санааг тусад нь салгаж тусгах нь зүйтэй.	Энэхүү хэсгийг дахин найруулан бичих шаардлагатай буюу уг заалтад тусгагдсан үйлдлүүдийг тус тусад нь ялган бичих
4	6.1.4.үндэсний, бусад улсын, улс хоорондын, бүс нутгийн эсхүл олон улсын түвшний төрийн бус байгууллага, тэдгээрийн эвсэл, сүлжээтэй харилцах, хамтран ажиллах;	Энэ хэсгийн“бусад улсын, улс хоорондын, бүс нутгийн эсхүл олон улсын түвшний” төрийн бус байгууллагууд нь агуулгын хувьд давхцаж байгааг анхаарах.	Энэхүү заалтын “бусад улсын, улс хоорондын, бүс нутгийн эсхүл олон улсын түвшний” гэсэн хэсгийг дахин найруулах
5	6.1.6.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангахад шаардлагатай хууль тогтоомжоор төрийн болон бусад байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг төр, хувийн хэвшил, иргэний нийгмээс аливаа хэлбэрээр хүлээж авах, эрж хайх, олох, мэдэх, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;	Энэхүү хэсгийг хууль хэрэглэгчийн зүгээс уншихад ойлгомжгүй байна.	Энэхүү заалтыг өөрчлөн найруулах
6	6.1.8. төрийн үйл хэрэгт оролцох , төрийн байгууллага, албан тушаалтныг хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах,	Энэхүү хэсэгт “ төрийн үйл хэрэгт оролцох ” гэдгийг ямар хүрээнд ойлгох нь тодорхойгүй тусгагджээ.	Энэхүү хэсгийн “ төрийн үйл хэрэгт оролцох ” гэдгийг

	хамгаалах чиг үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор шүүмжлэх, санал, хүсэлт тавих, гомдол гаргах, зөвлөгөө өгөх, хүний эрхийн зөрчил, хууль бус үйлдэлд анхаарлыг нь хандуулах, энэ талаар бусдад мэдээлэх;		ойлгомжтой байдлаар томъёолох
7	6.1.10.төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдлийн талаар гаргасан гомдлыг бус нутгийн болон олон улсын хүний эрхийн байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх;	Энэ хэсгийн бус нутгийн гэж томъёолсон нь ойлгомжгүй болжээ.	Энэхүү хэсгийг уг хуулийн төслийнүзэл баримтлалтай нийцүүлэн өөрчлөн найруулах
8	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 8 дугаар зүйлийн 8.1-д тусгасан “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасныг тодруулах	Энэхүү дурдсан зүйл заалтад “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасан нь хуулийг хэрэглэгч субъектүүдэд ойлгомжгүй болжээ.	Төслийн зарим зүйл заалтад “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэж томъёологдсон нь ойлгомжгүй болсон тул хууль хэрэглэгчийн зүгээс ойлгоход энгийн байдлаар уг зүйл заалтыг өөрчлөн найруулах
9	6.1.11.хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хурал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нээлттэй сонсголд ажиглалт хийх, төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомж болон олон улсын холбогдох хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд байр сууриа илэрхийлэх, дүгнэлт өгөх;	Энэ хэсэгт хүний эрхийн хамгаалагч нь шүүх хурал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нээлттэй сонсгол мөн төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомж болон олон улсын холбогдох хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд дүгнэлт өгөх гэсэн агуулгаар ойлгогдож байна. Хүний эрхийн хамгаалагч нь дүгнэлт өгөх эрхтэй болох нь зохистой эсэхийг тодруулах.	Энэ хэсгийн дүгнэлт өгөх гэснийг тодорхой болгох

11	6.1.17.хүний эрхийн талаарх шинэ ойлголт, зарчмуудыг боловсруулах, хэлэлцэх, таниулах, тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх.	Энэхүү хэсгийг хууль хэрэглэгчийн зүгээс уншихад ойлгомжгүй байна.	Энэ хэсгийг дахин найруулан бичих
12	8.1.3.хүний эрхийн хамгаалагчдын талаарх ажиллагсдынхаа мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах.	Энэхүү хэсгийг хууль хэрэглэгчийн зүгээс уншихад ойлгомжгүй байна.	Энэ хэсэгт тусгагдсан төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдүүд хүний эрхийн хамгаалагчид халдах байдал гардаг гэж ойлгогдохоор байна. Иймээс энэ хэсгийн агуулгыг дахин найруулах.
13	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.12, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.2.2, 9.3, 14 дүгээр зүйлийн 14.2-т тус тус заасан “холбогдох” гэсэн нь ойлгомжгүй болсныг тодруулах.	Эдгээр зүйлд тусгагдсан “холбогдох” гэдэг нь ойлгомжгүй байна.	“холбогдох” гэдгийг ойлгомжтой байдлаар өөрчлөн найруулах.
14	9.2.2.хүний эрхийн хамгаалагч амь насаа алдсан, сураггүй алга болсон, эрүү шүүлтэд өртсөн, хууль бусаар баривчлагдсан зэрэг тохиолдолд нэн даруй, НЯГТ НЯМБАЙ, ҮР ДҮНТЭЙ , хараат бус, шударга мөрдөн шалгах ажиллагааг төрийн эрх бүхий мөрдөх байгууллага явуулах;	Энэ заалтын “нягт нямбай”, “үр дүнтэй”, “эрх бүхий мөрдөх байгууллага” гэдэг нь ойлгомжгүй тусгагджээ.	Энэ хэсгийг ойлгомжтой байдлаар томъёолох
15	11.1.Иргэний нийгмийн байгууллагуудаас Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ: 11.1.1.хүний эрхийн хамгаалагчаар ажилласан	Энэ хэсэгт иргэний нийгмийн байгууллагуудаас хорооны гишүүнд тавих шаардлагыг тодорхойгүй тусгажээ.	Энэ хэсгийн иргэний нийгмийн байгууллагуудаас хорооны гишүүнд тавигдах шалгуур, сонгогдох процесс

<p>туршлагатай, 11.1.2.хүний эрхийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, 11.1.3.олон улсын, бүс нутгийн, үндэсний сүлжээнд ажилладаг, хүлээн зөвшөөрөгдсөн, 11.1.4.Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод, Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг зэрэг олон улсын механизмд хөндлөнгийн хараат бус илтгэл бичиж, хэлэлцүүлсэн байх, 11.1.5. ёс зүй, ёс суртахуунтай байх.</p>		<p>ажиллагаа зэргийг ойлгомжтой байдлаар тусгах</p>
--	--	---

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. Үүнд:

<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</p>	
<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</p>	<p>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</p>
<p>29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;</p>	<p>- Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Улсын Их Хурал” гэж тусгасан нь хуулийн нэршлийн хувьд алдаатай болсон байна. Иймд уг нэршлийг Монгол Улсын Үндсэн хууль ба бусад хуульд тусгагдсан буюу тогтсон нэршлээр нь бичих шаардлагатай.</p> <p>- Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т “хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа чөлөөтэй зорчих, аль ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид ажиллах” гэж тусгасан. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй.” гэж тусгасантай агуулгын хувьд давхардсан тул энэ заалтыг хасах.</p>

<p>29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;</p>	<p>Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах асуудлыг энэ хуульд заасан журмаар зохицуулна.” гэж тусгасан боловч энэ хуулиар гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагчийн үйлдэл, үйл ажиллагааг хэрхэн зохицуулах талаарх зохицуулалт дутмаг байна.</p>
<p>29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;</p>	<p>Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “хүний эрхийн хамгаалагчид халдах” гэж “хүний эрхийн хамгаалагчийн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан түүнд болон түүний гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, төрөл, садангийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг доромжлох, гүтгэх, хуурч мэхлэх, залилах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, худал цуу тараах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байх, дэмжихгүй байхыг уриалах, хууль бус шийдвэр гаргах, үүрэг өгөх, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөн мөшгих, амь нас, эрүүл мэндийг хохироох, бие махбодийг нь гэмтээх, өмч, эд хөрөнгөд нь гэм хор учруулах, түүнчлэн эдгээрт бэлтгэх, завдахыг.” ойлгоно гэж тусгажээ. Үүнээс харахад энэ заалтын хүрээнд хүний эрхийн хамгаалагчид халдах үйлдлийг маш өргөн хүрээгээр тусгажээ.</p>
<p>29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;</p>	<p>Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Хороо нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бие даасан, хараат бус байдлаар ажиллана.” гэж тусгасан боловч уг төслийн 10.4-т “Хорооны дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга байх” гэж тусгасан нь зөрчилтэй болжээ.</p>
<p>29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;</p>	<p>7.1 Хүний эрхийн хамгаалагч дараах үүргийг хүлээнэ: 7.1.1.хүчирхийллийн бус арга, тайван замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах; 7.1.2.хүний эрхийн хамгаалагчийн алдар хүнд, нэр төрийг хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх; 7.1.3.ёс зүй, ёс суртахуунтай байж хүний эрх, эрх чөлөө, нийгмийн үнэт зүйлсийг хүндэтгэх. 7.1.4.хүний эрхийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх гэсэн тунхагласан шинжтэй зүйлийг тусгасан байна.</p>

<p>29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;</p>	<p>Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хүний эрхийн үндэсний комиссын тухай зэрэг хуулийн зүйл, заалтыг уг төсөлд тусгасан боловч эдгээр хуулиудаас эш татаж хэрэглээгүй, давхардуулан тусгагдсан байна.</p>
<p>29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд Улсын Их Хурал, цагдаагийн байгууллага, Гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагчийн Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах асуудлыг тусгасан боловч эдгээр субъектийн хэрэгжүүлэх чиг үүрэг, эрх хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой тусгагдаагүй.</p>
<p>29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;</p>	<p>Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан зохих хариуцлага хүлээлгэнэ.”, 14.2-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тодорхойгүй байдлаар тусгасныг тодорхой болгох.</p>
<p>29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;</p>	<p>Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.</p>
<p>29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Хуулийн төсөлд “дараах” гэсэн үгнүүд тусгагдсан ба үүнийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн “дараахь” болгон өөрчлөх шаардлагатай. Мөн хуулийн төсөлд “нягт нямбай” гэх зэрэг ярианы үг орсон байдлыг анхаарах.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Хуулийн төсөлд “алдар хүнд”, “эрхэм чанар”, “нэр төр” зэрэг ойролцоо үг хэллэг ашигласан нь нэр томъёоны хувьд ойлгомжгүй болсныг анхаарч нэр томъёог жигдрүүлэх.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хуулийн төсөлд ёс зүйтэй байх, ёс суртахуунтай байх гэх зэрэг хоёрдмол утгатай холбоо үгнүүдийг ойлгомжтой байдлаар томъёолох.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараахь асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	-Хуулийн төслийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан, бусад хуулийн этгээд нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахдаа чиг үүргийн хувьд хэт ерөнхий байдлаар төсөлд тусгагдсан. Иймээс уг төслийн 1 дүгээр зүйлд заасан зорилтыг хангахын тулд хуулийн төслийн холбогдох хэсгийг дахин найруулах шаардлагатай.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

<p>Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх</p>	<p>Хуулийн төсөлд ёс зүйтэй байх, ёс суртахуунтай байх гэх зэрэг хоёрдмол утгатай холбоо үгнүүдийг ойлгомжтой байдлаар томъёолох, мөн “дараах” гэсэн үгийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн “дараахь” болгон өөрчлөх</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх</p>	<p><i>Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо нийцэж байгаа эсэх:</i></p> <p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p> <p><i>Хуулийн төслийн зүйл заалт бусад хуультай нийцэж байгаа эсэх:</i></p> <p>-Хуулийн төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан хүний эрхийн хорооны үйл ажиллагаа нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгасан Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэгтэй зарим талаар давхцсан байна.</p> <p>Мөн уг төслийн 8, 9 дүгээр зүйлд тусгагдсан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, чиг үүрэг нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудтай давхцаж байгаа зөрчлийг арилгах.</p> <p>- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т тусгагдсан “төрийн бус байгууллага” гэх нэр томъёоны тодорхойлолтыг Иргэний хуулийн 25 дугаар зүйл болон Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулгатай нийцүүлэн томъёолох</p>
<p>Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх</p>	<p>Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т “хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа чөлөөтэй зорчих, аль ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид ажиллах” гэж тусгасан. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардан тусгагдсан. Иймд 6.1.1.3 дахь заалтыг хасах.</p>
<p>Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх</p>	<p>Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.</p>
<p>Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх</p>	<p>-Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах асуудлыг энэ хуульд заасан журмаар зохицуулна.” гэж тусгасан боловч уг заалтыг</p>

	хэрхэн хэрэгжүүлэх тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Иймээс энэхүү заалтыг хэрхэн хэрэгжүүлэх тухай нарийвчилсан зохицуулалтыг төсөлд тусгах
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	-Хуулийн төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан хүний эрхийн хорооны үйл ажиллагаа нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгасан Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэгтэй зарим талаар давхцсан байна. Мөн 8, 9 дүгээр зүйлд тусгагдсан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, чиг үүрэг нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудтай давхцаж байгааг анхаарах.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Энэ хуулийн төслөөр татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон зохицуулалт байхгүй.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Энэ хуулийн төслөөр шинээр тусгай зөвшөөрөл бий болгох зохицуулалт байхгүй.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн, бий болгосон заалт байхгүй.
Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан зүйл, заалт тогтоогдоогүй болно.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан зохих хариуцлага хүлээлгэнэ.”, 14.2-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тодорхойгүй байдлаар тусгасныг ойлгомжтой, тодорхой болгох.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Гадаад орнуудын туршлагаас үзэхэд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, үйл ажиллагааг нь хүлээн зөвшөөрөх, эрхийг нь хамгаалах эрх зүйн зохицуулалтын хүрээнд Тунхаглалын ерөнхий зарчмыг баримталж, Загвар хуулийн үндсэн зохицуулалтыг харгалзахаас гадна манай улсад хэрэгжихүйц хэлбэрээр нутагшуулах нь зүйтэй гэж үзэж байна. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараахь байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд хүний эрхийг хангах, хамгаалах талаарх суурь эрхүүдийг тусгасан нь хуулийн төсөлд тавигдсан зорилгодоо нийцэж байна. Гэвч эдгээр эрхийг хүний эрхийн хамгаалагчийн эрх гэж явцууруулан тусгасан нь учир дутагдалтай болжээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд уг хуулийн төслийн зорилгыг “хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах зорилготой” байна гэж тусгасан боловч энэхүү зорилгыг хангахад шаардлагатай зохицуулалтууд тодорхойгүй буюу хэт ерөнхий байдлаар тусгагдсан байна. Үүнээс үүдэн уг хуулийн төсөлд тавигдсан зорилго хангахад учир дутагдалтай болжээ.

Тухайлбал, “хүний эрхийн хамгаалагч” гэж хэн болох, “хүний эрхийг хүндэтгэх” гэж юуг ойлгох, хүний эрхийн зөрчсөн ямар үйл ажиллагааг “хүний эрхийн зөрчил” гэж үзэх, “хүний эрхийг хамгаалагчид халдах” гэж юуг ойлгох, мөн хүний эрхийг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг, ажлын уялдаа холбоо зэргийг тодорхой тусгаж өгөөгүй байна.

Түүнчлэн, хүний эрхийн хамгаалагчид халдсан үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаанд хамаарах 9.2.2 дугаар заалт нь одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн санаатай үйлдсэн эсэхийг шалгах зохицуулалтыг ямар нэг байдлаар өөрчлөөгүй буюу шинэ нөхцөл байдал үүсгээгүй байна. Мөн “хүний эрхийн хамгаалагч амь насаа алдсан, тохиолдолд нэн даруй, нягт нямбай, үр дүнтэй, хараат бус, шударга мөрдөн шалгах ажиллагааг” явуулна гэж заасан нь уг хуулийн төслийн дагуу зөвхөн хүний эрхийн хамгаалагчтай холбогдох тохиолдлыг нягт нямбай, үр дүнтэй шалгах хэрэгтэй гэх өрөөсгөл байдлаар ойлгогдохоор томъёологдсон байна.

Мөн хуулийн төслийн 9.3 дахь хэсэг нь тус зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект тодорхойгүй тул үр нөлөөтэй хэрэгжих боломжгүй байна.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгох зохицуулалтын тухайд Цагдаагийн байгууллагын чиг үүргийг дахин тодотгож, Хороонд шуурхай арга хэмжээ авах, эрсдэлийг үнэлэх, хамгаалалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох эрх хэмжээ олгосон боловч ямар процесс, журмаар хэрэгжих нь тодорхойгүй байна. Түүнчлэн хуулийн төсөлд хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий субъектуудыг тусгасан боловч эдгээр субъектуудын хоорондын уялдаа, хамтын ажиллагаа

тодорхойгүй байгаа тул практикт бүрэн хэрэгжиж, зорилгод бүрэн хүрэх боломжгүй гэж үзэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэллээ.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг зарим талаар хангаагүй, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг зарим тохиолдолд баримтлаагүй байна гэж үзлээ. Тухайлбал, Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.6, 6.1.8, 6.1.10, 6.1.11, 6.1.17, 8 дугаар зүйлийн 8.1.3, 9 дүгээр зүйлийн 9.2.2, 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.5 дахь тус тус зүйл, заалтууд ойлгомжгүй томъёологдсон;

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 8 дугаар зүйлийн 8.1-д тус тус заасан “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасан нь хэрэгжүүлэх эрх бүхий субъектийг ойлгомжгүй томъёолсон;

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.12, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.2.2, 9.3, 14 дүгээр зүйлийн 14.2-т тус тус заасан “холбогдох” гэж тусгасан нь хэрэгжүүлэх эрх бүхий субъектийг ойлгомжгүй томъёолсон;

Уг хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагын 29 дүгээр зүйлийн 29.1.1-29.1.3, 29.1.5-29.1.9 дахь заалтуудад тавигдсан нийтлэг шаардлагуудыг хангаагүй байна.

Уг хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын 30.1.4, 30.1.5 дахь заалтуудад тусгасан шаардлагыг хангасан боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-30.1.3-т заасан “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх”, “Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх”, “Үг хэллэгийг Монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэсэн шалгуурыг зарим талаар хангаагүй байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлуудыг тодруулж, хуулийн төслийн дотоод болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай байх 14 төрлийн асуулгаас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл нь 7 төрлийн асуулгын шаардлагыг хангасан, уялдаа холбоотой болсон байна гэж дүгнэлээ.

Харин шалгуур үзүүлэлтэд заасан Тасуулга бүхий шалгуур үзүүлэлтийг хангаагүй хэсэгт дараахь зүйл, заалтууд хамаарч байна. Тухайлбал,

1/ Хуулийн төслийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан, бусад хуулийн этгээд нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахдаа чиг үүргийн хувьд хэт ерөнхий байдлаар төсөлд тусгагдсанаас үүдэн уг төслийн 1 дүгээр зүйлд заасан зорилтыг хангахад учир дутагдалтай болсон.

2/ Хуулийн төсөлд ёс зүйтэй байх, ёс суртахуунтай байх гэх зэрэг хоёрдмол утгатай холбоо үгнүүд тусгагдсан;

3/ *Хуулийн төслийн зүйл заалт бусад хуультай нийцэж байгаа эсэх заалтуудын талаар:*

- Хуулийн төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан хүний эрхийн хорооны үйл ажиллагаа нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгасан Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэгтэй зарим талаар давхцсан байна.

- Хуулийн төслийн 8, 9 дүгээр зүйлд тусгагдсан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, чиг үүрэг нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудтай давхцсан.

- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т тусгагдсан “төрийн бус байгууллага” гэх нэр томъёоны тодорхойлолтыг Иргэний хуулийн 25 дугаар зүйл болон Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулгатай нийцүүлэх.

4/ Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т “хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа чөлөөтэй зорчих, аль ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид ажиллах” гэж тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардан тусгагдсан.

5/ Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах асуудлыг энэ хуульд заасан журмаар зохицуулна.” гэж тусгасан боловч уг заалтыг хэрхэн хэрэгжүүлэх тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

6/ Хуулийн төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан хүний эрхийн хорооны үйл ажиллагаа нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгасан Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэгтэй зарим талаар давхцсан байна. Мөн 8, 9 дүгээр зүйлд тусгагдсан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, чиг үүрэг нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудтай давхцаж байгааг анхаарах.

7/ Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан зохих хариуцлага хүлээлгэнэ.”, 14.2-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тодорхойгүй байдлаар тусгасныг ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай дүгнэлт, саналыг гаргаж байна.

4.2. Зөвлөмж

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хүний эрхийн хамгаалал, тэр дундаа хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, түүний эрх зүйн байдлыг тодорхойлох зэрэг асуудлуудыг тусгасан нь чухал ач холбогдолтой болжээ. Энэ хууль батлагдсанаар цаашид хүний эрхийг хамгаалах, хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлыг сайжруулахад эерэг үр дагавар бий болгоно гэж үзэж байна. Иймээс энэ хуулийн төслийг батлах нь зүйтэй гэж төслийн үнэлгээний баг үзлээ. Ингээд Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үнэлгээгээр тогтоогдсон үр дүнд тулгуурландараахь зөвлөмжийг хүргүүлж байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Хуулийн төсөлд “хүний эрхийн хамгаалагч”, “хүний эрхийг хүндэтгэх”, “хүний эрхийн зөрчил”, “хүний эрхийг хамгаалагчид халдах”, мөн хүний эрхийг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг, ажлын уялдаа холбоо зэргийг тодорхой тусгаагүй байна. Иймээс эдгээр ойлголтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

Мөн хуулийн төсөлд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог Хүний эрхийн үндэсний комиссын дэргэд бие даасан хороо байгуулах замаар тусгасан байна. Энэ нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуультай зөрчилдөж байгаа учраас хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах бие даасан чиг үүрэг бүхий хороог байгуулахгүй байх нь зүйтэй гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, энэхүү хороог байгуулахгүйгээр энэ чиг үүргийг Хүний эрхийн үндэсний комисст давхар хариуцуулах нь нэг талаас уг хуулийн зөрчлийг арилгах нөгөө талаас эдийн засгийн зардал хэмнэх давхар ач холбогдолтой.

Түүнчлэн уг хуулийн төслийн 6 дугаар зүйлд заасан хүний эрхийг хангах, хамгаалах ажиллагааг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуульд нийцүүлэн тусгах, мөн энэ талаарх эрхийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог тодорхой болгох.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт тусгагдсан зохицуулалтыг хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгох. Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд Хороо тодорхой бүрэн эрх эдлэхгүй тохиолдолд хуулийн зохицуулалтын дээрх хэсгийг гадаадад Монгол Улсын иргэнийг хамгаалах чиг үүрэг бүхий дипломат байгууллагын үүрэг гэсэн хэсэг болгон өөрчлөх. Харин дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд Хороо тодорхой үүрэг гүйцэтгэх тохиолдолд гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах журмыг Хороо болон Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоох.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хамгаалалтын тогтолцоо бий болгохтой холбогдох, энэхүү үнэлгээгээр шалгаж зөрчилтэй гэж тогтоогдсон зүйл, заалтыг өөрчлөх, мөн хүний эрхийг хангах, хамгаалах

чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, чиг үүргийн уялдааг тодорхой болгох.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.6, 6.1.8, 6.1.10, 6.1.11, 6.1.17, 8 дугаар зүйлийн 8.1.3, 9 дүгээр зүйлийн 9.2.2, 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.5 дахь тус тус зүйл, заалтыг ойлгомжгүй томъёолсон учраас эдгээр заалтыг ойлгомжтой болгон өөрчлөх;

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 8 дугаар зүйлийн 8.1-д тус тус заасан “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасныг ойлгомжтой байдлаар төсөлд тусгах;

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.12, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.2.2, 9.3, 14 дүгээр зүйлийн 14.2-т тус тус заасан “холбогдох” гэх зэргээр тусгасныг ойлгомжтой байдлаар төсөлд тусгах;

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.1.8, 6 дугаар зүйлийн 6.1.13, 7 дугаар зүйлийн 7.1.1-7.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 10 дугаар зүйлийн 10.2, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-29.1.3, 29.1.5-29.1.9 дахь заалтуудад тавигдсан нийтлэг шаардлагуудыг хангаагүй байгаад анхаарч ойлгомжтой байдлаар төсөлд тусгах;

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-30.1.3-т заасан “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх”, “Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх”, “Үг хэллэгийг Монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэсэн шалгуурыг зарим талаар хангаагүй байгаа байдалд анхаарч ойлгомжтой байдлаар тусгах.

Харилцан уялдаатай байх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Харилцан уялдаатай байх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1/ Хуулийн төслийн 8, 9, 10 дугаар зүйл нь уг төслийн 1 дүгээр зүйлд заасан зорилтыг хангахад тодорхойгүй байгаа учраас эдгээр зүйл, заалтыг өөрчлөн найруулах;

2/ Хуулийн төсөлд ёс зүйтэй байх, ёс суртахуунтай байх гэх зэрэг хоёрдмол утгатай холбоо үгнүүд байгааг анхаарах, мөн “дараах” гэж бичсэнийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн “дараахь” болгон өөрчлөх;

3/ *Хуулийн зүйл заалт бусад хуультай нийцэж байгаа эсэх заалтууд:*

- Хуулийн төслийн 10 дугаар зүйл нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгасан Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэгтэй зарим талаар давхцсан байгааг анхаарах;
 - Хуулийн төслийн 8, 9 дүгээр зүйл нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудтай

давхцаж байгаа зөрчлийг арилгах;

- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т тусгагдсан “төрийн бус байгууллага” гэх нэр томъёоны тодорхойлолтыг Иргэний хуулийн 25 дугаар зүйл болон Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулгатай нийцүүлэн томъёолох;

4/ Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.13 дахь заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардсан байдлыг харгалзан уг заалтыг хасах;

5/ Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хэрхэн хэрэгжүүлэх тухай нарийвчилсан зохицуулалтыг төсөлд тусгах;

6/ Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д тусгагдсан хуулийн хариуцлагыг ойлгомжтой байдлаар тусгах гэсэн санал, зөвлөмжийг гаргаж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль

Монгол Улсын Үндсэн хууль
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль
Хууль тогтоомжийн тухай хууль
Эрүүгийн хууль
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Гадаад эх сурвалж

Lynch, Phil, Madeleine Sinclair, Marta Kolasi, and Michael Ineichen, 'From Restriction to Protection', 2014
Eguren, E. (2005). *Protection Manual for Human Rights Defenders*. Retrieved from www.frontlinedefenders.org
Protection International. (2012). *Protection of human rights defenders: Best practices and lessons learnt*.
Mcevoy, T., Leather, B., Lynch, P., & Ineichen, M. (2016). In the eyes of the law: Human rights defenders demand national legal recognition and protection Full consultation report, (February).
Studies, H. R. (2012). Questionnaire on use of legislation to regulate activities of human rights defenders – Special Rapporteur on the situation of Human Rights Defenders.

Бусад эх сурвалж

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал.
Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга.

-----oOo-----

ХАВСРАЛТ

Нэг. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухам хуулийн төслийн үзэл баримтлал

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж”, Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байна. Төрийн зүгээс аливаа тохиолдолд өөрийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэн бүрт аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэг хүлээсэн бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний илрэл болсон иргэний нийгмийг хөхиүлэн дэмжих, бэхжүүлэх ёстой.

Гэтэл хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг аюул, эрсдэл, саад бэрхшээлийг арилгах, тэдний үйл ажиллагааг дэмжих нь дэлхий нийтийн хувьд анхаарал хандуулах шаардлагатай асуудал болсон тул 1999 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблей “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хамгаалж буй хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллагуудын эрх, үүрэг хариуцлагын талаарх тунхаглал” (Хүний эрхийг хамгаалагчдын эрхийн тунхаглал)-ыг баталж, 2000 онд хүний эрхийг хамгаалагчийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийг томилжээ. Филиппин улсын Манила хотод 2014 онд зохион байгуулсан Азийн бүсийн хүний эрхийг хамгаалагчийн Чуулганаас баталсан “Манилагийн хоёрдугаар тунхаглал”-д хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагаа явуулах орон зай, эрх чөлөө нь хязгаарлагдаж, эрсдэл, бэрхшээл тулгарч байгааг анхаарч, хуульд нийцсэн үйл ажиллагааны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хязгаарлах, аливаа заналхийлэл, дарамт шахалтыг зогсоож, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийг хамгаалагчийн тухай тунхаглалын зарчмыг баримтлахыг бүс нутгийн улс орнуудад уриалсан байна. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2010 онд Монгол Улсын Засгийн газарт “хүний эрхийг хамгаалан тэмцэгчдийг хамгаалах”-ыг зөвлөсөн байдаг.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2014 онд шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын албан хаагч, өмгөөлөгч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллагын ажилтан, хүний эрхийг хамгаалагч, идэвхтэн зэрэг 1375, “Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа” судалгаанд Улаанбаатар хот, 21 аймгаас үйлдвэрчний эвлэлийн гишүүн, идэвхтэн, сонгуульт ажилтан 3662 хүнийг хамруулан “Хүний эрхийг хамгаалагчийн эрхийн хэрэгжилт” болон “Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааны баталгаа” судалгаа хийсэн юм.

Уг судалгаанаас үзэхэд хүний эрхийн төлөө ажилласныхаа төлөө амь нас, бие махбодод нь халдах, заналхийлэлд өртөх, нэр төр, алдар хүндэд халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим хэлбэрээр халдлагад өртөх, мэдээлэл авах боломжийг хязгаарлах, мэдээлэл өгөхөөс татгалзах, үйл ажиллагааг нь үгүйсгэх, үл ойшоох, төвөгшөөх, төрийн байгууллагын зүгээс хүнд суртал гаргах, ялгаварлах, шударга бус хандах, цалин, нийгмийн халамжийг хязгаарлах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байдаг. Түүнчлэн жилээс жилд хүний эрхийн хамгаалагчдад халдах халдлага улам олширч, нарийсахын хамт тоо нэмэгдэж байна. Хүний эрхийн чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагуудыг төрөөс төдийлөн дэмждэггүй, төсөл дуусахаар тухайн төрийн бус байгууллагын үйл ажиллагаа зогсох хандлага нийтлэг байгаагаас шалтгаалан хүний эрхийг хамгаалах иргэний нийгмийн үйл ажиллагаа сулрахад хүрдэг байна.

Хүний эрхийг хамгаалагчдын эрхийн тунхаглал нь хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагааг хориглох, хүндрэл учруулах, хүний эрхийн зөрчлийг хууль ёсны гэж үзэх явдлаас сэргийлэх зорилготой төдийгүй төрийн зүгээс тусгайлан биелүүлэх үүрэгтэйг онцолсон билээ. Мөн хүний эрхийн олон улсын гэрээгээр баталгаажуулсан хэм хэмжээг бие даасан хуулиар дахин баталгаажуулах, хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлыг хангахад чиглэсэн байна. Олон улсын хамтын нийгэмлэгээс ийнхүү тодорхойлох болсон нь дараах үндэслэлтэй.

Нэгдүгээрт, Монгол Улсыг оролцуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсуудад хүний эрх, эрх чөлөөнд халдахтай тэмцэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулж буй хувь хүнд төр, хувийн хэвшлийн зүгээс халдах, дарамтлах, үйл ажиллагааг нь зогсоох явдал түгээмэл байна. Иймээс “хүний эрхийн хамгаалагч” гэж хэн болох, “хүний эрхийн зөрчил”-ийг хэрхэн үнэлэх тухай тусгайлан тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байхгүй, үндэсний хэмжээнд зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоо байхгүй ажээ.

Хоёрдугаарт, төрийн болон төрийн бус зарим байгууллагын зүгээс хүний эрхийн хамгаалагчдын хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нийгэмд гүйцэтгэж байгаа хувь нэмрийн талаарх мэдлэг ойлголт бага, хүлээн зөвшөөрөх, хамтран ажиллахаас илүүтэй “сөрөг хүчин” байдлаар үзэх шүүмжлэлт хандлага тогтсон, төрийн зарим үүргийг нөхөж ажиллах боломжийг үгүйсгэсэн байдаг. Иргэний нийгмийн зүгээс төрийг шүүмжлэх хандлагатай, хамтач байдлаар ажилласан туршлага багатай, хүчирхийллийн бус аргаар хууль ёсны дагуу тэмцэх арга, хэлбэрийг хуулиар бүрэн зохицуулаагүй, ёс суртахуун, үнэт зүйлийг шалгуур болгосон заалт байхгүй билээ.

Гуравдугаарт, өдөр тутам хүн ам нэмэгдэж, өсөн тэлж байгаа улсуудын хувьд эв найртай зэрэгцэн орших, нийгмийн ахиц, дэвшилд хамтдаа хүрэх, хүчирхийлэл, айдас, гачигдлаас ангид байхын тулд аливаа этгээдийн хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах нь хөгжлийн үндэс билээ. Төрийн зүгээс төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэнцвэрт орон зайг хангах, эрх мэдлээр далайлган төрийн зүгээс хүний эрхийн зөрчлийг үйлдэх эсвэл хүлээн зөвшөөрөх, нөгөө талаас хувийн хэвшлийн зүгээс эдийн засгийн чадавх, хөрөнгө чинээгээр түрэмгийлэн шударга ёсыг үл тоох, тэгш бус байдлыг гааруулахаас сэргийлэх

шаардлагатай. Үүнтэй уялдан эрх мэдэл, эдийн засгийн чадавхгүй иргэний нийгмийн төлөөллийг эн тэнцүү үзэх, шийдвэр гаргах, бодлого боловсруулах, төрийн тогтолцоог ажиллахад хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх нь чухал. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бий болгох замаар адил тэгш, зохистой механизм бий болгох шаардлагатай.

Дөрөвдүгээрт, манай улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох үүрэг хүлээсэн ба Засгийн газрын зүгээс Хүний эрхийн Үндэсний Комиссын бүтцэд тусгах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Хараат бус, бие даан ажиллах боломжтой бүтцээр хүний эрхийн үндэсний байгууллагыг тодорхойлсон нь зардал багатай, үр бүтээмжтэй ажиллах тогтолцооны нэг хэсэг гэж үзэж байна.

Иймд, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бий болгох үүднээс энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь 4 бүлэг, 14зүйлээс бүрдэнэ.

Анх удаа “хүний эрхийн хамгаалагч”-ийг эрх зүйн үүднээс тодорхойлон, тэдний эрх зүйн байдлыг бие даасан хуулиар баталгаажуулж, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог байгуулах үүднээс энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслөөр хүний эрхийн хамгаалагчийн Үндсэн хууль, бусад хууль, олон улсын хүний эрхийн гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг дахин баталгаажуулахын зэрэгцээ өөрийн үйл ажиллагааг явуулахдаа хүлээх үүрэг, хариуцлагыг тусгайлан зааж өгсөн болно. Эрх мэдэл, эдийн засгийн байдал, хүний нөөц зэрэг олон хүчин зүйлсээр илүүрхэх, дарамтлах, шахах, халдах явдал түгээмэл байгааг таслан зогсоох, цаашид урьдчилан сэргийлэх зорилгоор нийгэмд ямар хэвшилд хамаарахаас үл шалтгаалан хүлээх нийтлэг үүргийг тусгав.

Үндэсний хэмжээнд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог хамгийн боломжит бага зардлаар байгуулахын тулд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бий болгохоор хуульд заасан ба гишүүд нь одоо чиг үүргээ гүйцэтгэж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллана. Тус хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд тусгайлан шалгуур тавьсан нь иргэний нийгмийн чадавхжуулах, дэмжих зорилготой бөгөөд хамтын шийдвэрээр анх удаа нэр дэвшүүлэх боломжийг бүрдүүллээ.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлгийн нэр томъёоны хэсэгт “хүний эрхийн хамгаалагч” гэж хэн болох, “төрийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг”, “хүний эрхийн хамгаалагчид халдах” үйлдлийг тусгайлан тайлбарласан

байна. Мөн “Хуулийн үндсэн зарчим” хэсэгт хүний эрхэм чанарыг хүндэтгэх, ёс зүйтэй байх зарчмыг тусгаснаар аливаа этгээдийн үйл ажиллагаанд удирдлага болгох чиглэлийг хуульчилжээ.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт хүний эрхийн хамгаалагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлохдоо хувь хүн ганцаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж ажиллахын тулд Үндсэн хууль, бусад хууль, хүний эрхийн олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрхийг улам өргөжүүлж, тусгайлан хамгаалсан байна. Хүний эрхийн хамгаалагчийн хүлээх үүргийн тухайд хүчирхийлэл үйлдэх, ямар нэгэн байдлаар хүний эрхийг зөрчих, эрх чөлөөнд халдахаас сэргийлсэн юм.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, хувь хүн байхаас үл хамааран хүний эрхийн хамгаалагчийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, тэдний талаар мэдлэг, ойлголтыг түгээх, мөн төрийн тусгайлан хүлээн үүргийг зааж, хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн баталгааг бий болгосон байна.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хорооны бүтцийг холимог бүрэлдэхүүнтэй байхаар тодорхойлсон. Тус хорооны гишүүдийн улс төр, эдийн засгийн баталгааг тусгайлан заахын хамт хорооны гишүүнд тавих шаардлага, иргэний нийгмийн байгууллагаас дэвшүүлэх журмыг тогтоосон байна. Мөн хорооны бүрэн эрх, ажлын зохион байгуулалтыг заахдаа одоогийн төрийн байгууллагын бүтцэд зардал багатай байх, хараат бус, бие даан ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны бүтцэд бие даасан нэгж ажиллахаар заасан. Уг хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тус бүлэгт тусгасан билээ.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх аргахэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаархүний эрхийн хамгаалагч, түүний үйл ажиллагааг тодорхойлох, иргэний нийгмийн хөхиүлэн дэмжих, хараат бус ажиллах, эрх мэдлийн хувьд гадуурхагдсан этгээдийг хамгаалж, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлдэг хүний эрхийн түгээмэлсоёл төлөвших нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Үүний тулд иргэний нийгмийн байгууллагуудаас хамтын шийдвэр гаргаж өөрсдийн төлөөллийг Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороонд нэр дэвшүүлэх журмыг мөрдөж ажиллана. Төр, иргэний нийгмийн төлөөлөл бүхий холимог бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг журмыг хэрэгжүүлэхэд хамтын шийдвэр гаргах, хяналт тавих байдлаар хэрэгжүүлнэ. Эдийн засгийн үүднээс хорооны бүтцэд ажиллах нэгжийн алба хаагч, тэдний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс хариуцахаас өөр нэмэлт зардал гарахгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хүний эрхийг хамгаалагчдын эрхийн тунхаглалын агуулга, үзэл баримтлал, гэрээгээр хүлээсэн үүрэгтэй нийцсэн, Үндсэн хууль, бусад холбогдох хууль, тэдгээрийн үзэл баримтлал, агуулга, зарчимтай бүрэн нийцсэн болно. Тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг тооцохоор заасан тул бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй болно.

Хоёр. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга

Дэлхий улсуудад аливаа шударга бус явдлын эсрэг, хүний эрх, эрх чөлөөг бодитойгоор эдлүүлэхийн төлөө тэмцэж буй хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагаа явуулах орон зай, эрх чөлөө нь хязгаарлагдах, заналхийлэл, дарамт шахалтанд орж буйг анхаарч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1998 оны A/RES/53/144 тогтоолоор “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал” (Хүний эрхийг хамгаалагчийн тухай тунхаглал) -ыг батлангаргаж, энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авахыг улс орнуудад уриалсан билээ.

Хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг хууль тогтоомжоордэмжихзорилгоор дэлхийн 40 гаруй улс хүний эрхийн хамгаалагчийн эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийг баталсан байна.

Манай улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсны төлөөамь нас, бие махбодод нь халдах, заналхийлах, дарамт шахалтад өртөх явдал цөөнгүй гарч байгаа ч хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжихэрх зүйн орчин бүрдээгүйбайна.

Иймд “хүний эрхийн хамгаалагч”-ийг эрх зүйн үүднээс анх удаа тодорхойлон, тэдний эрх зүйн байдлыг бие даасан хуулиар баталгаажуулж, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог байгуулах үүднээс энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хүний эрхийн төлөө олон улсын байгууллагаас (ISHR) гаргасан “Хүний эрхийн хамгаалагчийг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай” загвар хуульд тулгуурлан Хүний эрхийн Үндэсний Комиссын “Хүний эрхийг хамгаалагчийн эрхийн хэрэгжилт” болон “Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа” судалгаа болон “Хүний эрхийн төлөө олон улсын байгууллага”-аас дэлхийн 40 гаруй улс орнуудын хууль тогтоомжинд хийсэн судалгаа, НҮБ-ын тусгай илтгэгчийн зөвлөмж зэрэг холбогдох материалыг ашигласан болно.

Хуулийн төслийн бүтцийн талаар: Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль 4 бүлэг 14 зүйлтэй. Энэхүү хууль нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад оршино.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлгийн нэр томъёоны хэсэгт “хүний эрхийн хамгаалагч” гэж хэн болох, “төрийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг”, “хүний эрхийн хамгаалагчид халдах” үйлдлийг тусгайлан тайлбарласан. Мөн “Хуулийн үндсэн зарчим” хэсэгт хүний эрхэм чанарыг хүндэтгэх, ёс зүйтэй байх зарчмыг тусгаснаар аливаа этгээдийн үйл ажиллагаанд удирдлага болгох чиглэлийг хуульчилсан.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг улам өргөжүүлж, тусгайлан баталгаажуулахын зэрэгцээ үйл ажиллагаагаа явуулахдаа хүлээх үүрэг, хариуцлагыг тусгайлан зааж өгсөн болно.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн байхаас үл хамааран хүний эрхийн хамгаалагчийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, тэдний талаар мэдлэг, ойлголтыг түгээх, мөн төрийн тусгайлан хүлээн үүргийг зааж, хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн баталгааг бий болгосон байна.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт Үндэсний хэмжээнд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог хамгийн боломжит бага зардлаар байгуулахын тулд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бий болгохоор хуульд заасан ба гишүүд нь одоо чиг үүргээ гүйцэтгэж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллахаар тусгасан. Тус хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд тусгайлан шалгуур тавьсан нь иргэний нийгмийн чадавхжуулах, дэмжих зорилготой бөгөөд хамтын шийдвэрээр анх удаа нэр дэвшүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн.

Хуулийн төсөл батлагдсанаар хүний эрхийн хамгаалагч, түүний үйл ажиллагааг тодорхойлох, иргэний нийгмийн хөхиүлэн дэмжих, хараат бус ажиллах, эрх мэдлийн хувьд гадуурхагдсан этгээдийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг хүний эрхийн түгээмэл соёл төлөвших нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай харилцан уялдаатай боловсруулагдсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Гурав. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

... оны ... дугаар сарын ...-ны өдөр
Улаанбаатар хот

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад оршино.

2 дугаар зүйл. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлыг энэ хуулиар тодорхойлно.

3.2. Гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол улсын иргэний эрхийг хамгаалах асуудлыг энэ хуульд заасан журмаар зохицуулна.

3.3. Тусгайлсан хуулиар эрх зүйн байдал нь тодорхойлогдсон хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлыг тухайн хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуулийн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “хүний эрхийн хамгаалагч” гэж ганцаараа эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхиүлэн дэмжиж, тайван, хүчирхийллийн бус арга замаар хүний эрхэм чанарыг үндэсний болон олон улсын түвшинд хүндэтгэн хамгаалж байгаа хүнийг;

4.1.2. “хүний эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллагын албан тушаалтан болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн эрх бүхий этгээдээс Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөнд харшилсан аливаа үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах, үүргээ биелүүлэхгүй байхыг хориглосон үйл ажиллагааг;

4.1.3. “төрийн бус байгууллага” гэж төрийн байгууллага болон аж ахуйн нэгжээс бусад бүх байгууллагыг;

4.1.4. “хүний эрхийг хамгаалах” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн холбогдох байгууллагын чиг үүргийг;

4.1.5. “хүний эрхийг хангах” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц улс төр, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх төрийн үүргийг;

4.1.6. “гэр бүлийн гишүүн” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан, “Төрлийн хүн” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.5, “Садангийн хүн” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.6-д заасан хүнийг;

4.1.7. “хамтран амьдрагч” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хүнийг;

4.1.8. “хүний эрхийн хамгаалагчид халдах” гэж хүний эрхийн хамгаалагчийн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан түүнд болон түүний гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, төрөл, садангийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг доромжлох, гүтгэх, хуурч мэхлэх, залилах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, худал цуу тараах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байх, дэмжихгүй байхыг уриалах, хууль бус шийдвэр гаргах, үүрэг өгөх, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөн мөшгих, амь нас, эрүүл мэндийг хохироох, бие махбодийг нэгэмтээх, өмч, эд хөрөнгөд нь гэм хор учруулах, түүнчлэн эдгээрт бэлтгэх, завдахыг.

5 дугаар зүйл. Хуулийн үндсэн зарчим

5.1. Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан үндсэн зарчмуудаас гадна дараах тусгай зарчмыг баримтална:

5.1.1 хүний эрхэм чанарыг хүндэтгэх;

- 5.1.2 хуульд үндэслэх;
- 5.1.3. ялгаварлан гадуурхахгүй байх;
- 5.1.4.ёс зүйтэй байх;
- 5.1.5.хариуцлага зайлшгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6 дугаар зүйл. Хүний эрхийн хамгаалагчийн эрх

6.1 Хүний эрхийн хамгаалагч дараах эрхтэй байна.

6.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагаа явуулах;

6.1.2.хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх, хамгаалах зорилгоор албан болон албан бусаар төрийн бус байгууллага, эвсэл холбоо, бүлэг, түүнтэй адилтгах нэгдэл байгуулах, эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаанд нь оролцох;

6.1.3.тайван жагсаал, цуглаан санаачлах, зохион байгуулах, энэхүү үйл ажиллагаагаа хууль бус аливаа нөлөөллөөс ангид байлгах;

6.1.4.үндэсний, бусад улсын, улс хоорондын, бүс нутгийн эсхүл олон улсын түвшний төрийн бус байгууллага, тэдгээрийн эвсэл, сүлжээтэй харилцах, хамтран ажиллах;

6.1.5.хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах зорилгоор үндэсний болон олон улсын санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулах;

6.1.6.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангахад шаардлагатай хууль тогтоомжоор төрийн болон бусад байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг төр, хувийн хэвшил, иргэний нийгмээс аливаа хэлбэрээр хүлээж авах, эрж хайх, олох, мэдэх, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;

6.1.7.шинээр батлах хууль тогтоомжийн хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх, санал боловсруулах, хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийгсудлах, хөндлөнгийн үнэлгээ өгөх;

6.1.8.төрийн үйл хэрэгт оролцох, төрийн байгууллага, албан тушаалтныг хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах, хамгаалах чиг үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор шүүмжлэх, санал, хүсэлт тавих, гомдол гаргах, зөвлөгөө өгөх, хүний эрхийн зөрчил, хууль бус үйлдэлд анхаарлыг нь хандуулах, энэ талаар бусдад мэдээлэх;

6.1.9.бусдын эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор тухайн этгээдийн зөвшөөрлөөр төлөөлөх;

6.1.10.төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдлийн талаар гаргасан гомдлыг бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх;

6.1.11.хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хурал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нээлттэй сонголд ажиглалт хийх, төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомж болон олон улсын холбогдох хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд байр сууриа илэрхийлэх, дүгнэлт өгөх;

6.1.12.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар аливаа хүнд өөрийн нь хүсэлтээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад туслалцаа үзүүлэх, санал болгох;

6.1.13.хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа чөлөөтэй зорчих, аль ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид ажиллах;

6.1.14.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг албадан гаргах тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтээр уулзах, зөвлөгөө өгөх, туслах;

6.1.15.өөрт болон энэ хуульд заасан бусад хүн эрсдэлд өртсөн, өртөх нөхцөл бодитой бүрэлдсэн тохиолдолд гэрч, хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдтэй дүйцэхүйц хамгаалалт хүсэх;

6.1.16.зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, гомдол гаргах, хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах;

6.1.17.хүний эрхийн талаарх шинэ ойлголт, зарчмуудыг боловсруулах, хэлэлцэх, таниулах, тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх.

6.1.18.цахим мэдээлэлд хууль бусаар халдахаас хамгаалуулах

7 дугаар зүйл. Хүний эрхийн хамгаалагчийн үүрэг

7.1 Хүний эрхийн хамгаалагч дараах үүргийг хүлээнэ:

7.1.1.хүчирхийллийн бус арга, тайван замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

7.1.2.хүний эрхийн хамгаалагчийн алдар хүнд, нэр төрийг хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх;

7.1.3.ёс зүй, ёс суртахуунтай байж хүний эрх, эрх чөлөө, нийгмийн үнэт зүйлсийг хүндэтгэх.

7.1.4.хүний эрхийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

8 дугаар зүйл. Нийтлэг үүрэг

8.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, хүний эрхийн хамгаалагч хүчирхийллийн бус, тайван замаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;

8.1.2.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрхийн хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;

8.1.3.хүний эрхийн хамгаалагчдын талаарх ажиллагсдынхаа мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах.

9 дүгээр зүйл. Төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг

9.1. Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хүний эрхийн хамгаалагчийн талаарх бодлого боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

9.1.2.хүний эрхийн хамгаалагчийн зөрчигдсэн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгийн /гэм буруутай этгээд гаргах төлбөрийн чадваргүй нь шүүхээр тогтоогдсон/ эх үүсвэрийг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд хуваарилах.

9.2 Хүний эрхийн хамгаалагчийн талаар төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.цагдаагийн байгууллага нь хүний эрхийн хамгаалагчид халдсан халдлагыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу таслан зогсоох, хамгаалалтад авах;

9.2.2.хүний эрхийн хамгаалагч амь насаа алдсан,сураггүй алга болсон,эрүү шүүлтэд өртсөн, хууль бусаар баривчлагдсан зэрэг тохиолдолд нэн даруй,нягт нямбай, үр дүнтэй, хараат бус, шударга мөрдөн шалгах ажиллагааг төрийн эрх бүхий мөрдөх байгууллага явуулах;

9.3.Гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг дараах байдлаар хамгаална:

9.3.1.хүний эрхийн хамгаалагчийг төлөөлөх хууль ёсны төлөөлөгчийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгээр томилох;

9.3.2.хүний эрхийн хамгаалагчийг тухайн улс дахь дипломат төлөөлөгчийн газар хүлээн авах, хүний эрхийн хамгаалагчийн гэр, ажлын газарт эсхүл эрх чөлөөг нь хязгаарласан газарт нэвтрэх;

9.3.3.хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлын талаар хяналт шинжилгээ хийх, мэдээлэх;

9.3.4.хүний эрхийн хамгаалагчийн холбогдсон хэрэг маргааныг мөрдөн шалгах, шүүх ажиллагаанд оролцох, ажиглах;

9.3.5.өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрчийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, дэмжлэг үзүүлэх;

9.3.6.эмнэлгийн шаардлагатай туслалцаа үзүүлэх;

9.3.7.шаардлагатай зорчих баримт бичгийг яаралтай олгох;

9.3.8.хүний эрхийн хамгаалагчийн гэр бүлийн гишүүдтэй холбоо тогтоох, мэдээллээр хангах;

9.3.9.хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн боломжит арга хэмжээ авах;

9.3.10.нэн тэргүүнд шаардлагатай санхүүгийн туслалцаа үзүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГА

10 дугаар зүйл. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо

10.1.Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо(цаашид “Хороо” гэх) нь төр, олон нийтийн төлөөлөл бүхий хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэгтэй байгууллага мөн.

10.2.Хороо нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бие даасан, хараат бус байдлаар ажиллана.

10.3.Хороо нь дарга, 6 гишүүнтэй байна.

10.4.Хорооны дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга байх бөгөөд гишүүдэд Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын асуудал хариуцсан нэгжийн удирдлага, Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Бодлогын хэрэгжилт хариуцсан нэгжийн удирдлага, Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшин сонгогдсон дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

10.5.Хорооны дарга, гишүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

10.6.Хорооны дарга, гишүүд улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэх ба аливаа улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.7.Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

11 дүгээр зүйл. Хорооны гишүүнийг сонгох

11.1.Иргэний нийгмийн байгууллагуудаас Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:

11.1.1.хүний эрхийн хамгаалагчаар ажилласан туршлагатай,

11.1.2.хүний эрхийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг,

11.1.3.олон улсын, бүс нутгийн, үндэсний сүлжээнд ажилладаг, хүлээн зөвшөөрөгдсөн,

11.1.4.Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод, Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг зэрэг олон улсын механизмд хөндлөнгийн хараат бус илтгэл бичиж, хэлэлцүүлсэн байх,

11.1.5. ёс зүй, ёс суртахуунтай байх.

11.2.Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшүүлэх Хорооны 4 гишүүнийг дараах журмаар сонгоно:

11.2.1. Хүний эрхийн Үндэсний Комисс нээлттэй нэр дэвшүүлэх зарыг 6 сараас доошгүй хугацааны өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсаар түгээнэ.

11.2.2. Хүний эрхийн Үндэсний Комисс, тус комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөл, иргэний нийгмийн төлөөлөл бүхий ажлын хэсэг /цаашид ажлын хэсэг гэх/ нээлттэй зар түгээснээс хойш 6 сарын дараа нэр дэвшигчдийн жагсаалтыг нэгтгэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албаны цахим хуудсаар танилцуулна.

11.2.3. Ажлын хэсэг энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчдийг оролцуулсан нээлттэй сонголт хийж, нэр дэвшигчдийн талаар хэлэлцүүлэг явуулна.

11.2.4. Нээлттэй сонголын дараа ажлын хэсэг шалгаруулалт хийж, шаардлага хангасан нэр дэвшигчдийн материалыг шалгаруулсан талаарх тэмдэглэлийн хамт Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлд хүргүүлнэ.

11.2.5. Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн гишүүд нууцаар санал хурааж, хамгийн олон санал авсан 4 нэр дэвшигчийг Хорооны гишүүнээр сонгогдсонд тооцно.

11.3. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга хорооны гишүүдийг батламжилна.

11.4. Хорооны дөрвөн гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх ба нэг удаа улируулан сонгож болно.

11.5. Төрийн албанд шилжсэн, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар Хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжгүй болсон Хорооны гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх асуудлыг Хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

12.1. Хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. хүний эрхийн хамгаалагчид халдах, эрхийг нь зөрчихөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах;

12.1.2. хүний эрхийн хамгаалагчийн хууль ёсны үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих;

12.1.3. энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийх, шаардлагатай арга хэмжээ авах;

12.1.4.хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч, Хүний эрхийн Үндэсний Комисст шилжүүлэн шийдвэрлүүлэх;

12.1.5.хүний эрхийн хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлын дагуу түүнийг таслан зогсооход чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авах;

12.1.6.эрсдэлийн үнэлгээ хийх, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад шаардагдах хэрэгцээг тодорхойлох;

12.1.7.хүний эрхийн хамгаалагчид халдсан хэргийг мөрдөн шалгах явцад туслах, дэмжих, мэдээлэх, зөрчил гаргагчид хариуцлага хүлээлгэсэн эсэхийг мэдээлэх;

12.1.8.хүний эрхийн хамгаалагчид халдсаны улмаас түүнд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;

12.1.9. Монгол Улсын хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлыг “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-д тусгах.

12.1.10.үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулж, олон нийтэд тогтмол мэдээлж байх;

12.1.11.хувь хүний нууцыг хамгаалж ажиллах.

13 дугаар зүйл. Хорооны ажлын зохион байгуулалт

13.1.Хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь түүний хурал байна.

13.1.1.Хорооны хурлыг сард нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хуралдуулна.

13.1.2. Энэ хуульд заасан Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлыг Хорооны хурлаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

13.2.Хороо нь ажлын албатай байна. Хорооны ажлын албаны үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны бүтцэд бие даасан нэгж гүйцэтгэнэ.

13.2.1. Хорооны ажлын албаны ажиллах журмыг Хороо батална.

14 дүгээр зүйл. Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

14.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан зохих хариуцлага хүлээлгэнэ.

14.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.